



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/170

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 14.4 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 11/34 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталж, уг төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар (Г.Энхтайван)-т шилжүүлэн, худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, үр дүнг танилцуулж ажиллахыг үүрэг болгосугай.

2. Энэ захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэлээр нь санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Наранбаатар)-т, хавсралтын 1-20 дахь заалтад тусгагдсан төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ (Б.Мөнхбат)-т, хавсралтын 21, 22 дахь заалтад тусгагдсан төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Эрүүл мэндийн газар (Б.Бямбадорж)-т, хавсралтын 23 дахь заалтад тусгагдсан төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг "Ус сувгийн удирдах газар" ОНӨААТҮГ (Ц.Төрхүү)-т, хавсралтын 24 дэх заалтад тусгагдсан төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Онцгой байдлын газар (А.Дашням)-т, хавсралтын 25 дахь заалтад тусгагдсан төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Замын хөгжлийн газар (Г.Баярсайхан)-т, хавсралтын 26, 27 дахь заалтад тусгагдсан төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Хот байгуулалт, хөгжлийн газар (Ц.Тулга)-т, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтад нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (М.Баяраа)-т тус тус даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

Д.СУМЬЯАБАЗАР

111020000952

Нийслэлийн Засаг даргын 2022 оны  
 02 дугаар сарын 11-ний өдрийн  
 11/170 дугаар захирамжийн  
 хавсралт



НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2022 ОНД САНХҮҮЖИХ  
 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ  
 ЖАГСААЛТ

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх он	Дуусах он	Төсөвт өртөг	(сая төг)
					2022 онд санхүүжих дүн
1	7 дугаар сургуулийн барилгыг буулгаж, шинээр барих /Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо/	2022	2024	8,500.0	1,500.0
2	Сургуулийн барилга, 960 суудал /Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 4 дүгээр хороо/	2022	2024	10,100.0	1,000.0
3	85 дугаар сургуулийн спорт заалны барилга /Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 20 дугаар хороо/	2022	2023	1,400.0	500.0
4	Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 29 дүгээр хороо/	2022	2023	3,220.0	1,500.0
5	Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 8 дугаар хороо/	2022	2023	3,220.0	1,000.0
6	Дотуур байрны барилга худалдан авах /Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 21 дүгээр хороо/	2022	2022	400.0	400.0
7	Монголын Хүүхдийн ордны барилгын галын системийн шинэчлэлт /Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо/	2022	2022	98.3	98.3
8	Монголын Хүүхдийн ордны барилгын дотор цахилгааны шугам сүлжээний шинэчлэлт /Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо/	2022	2022	327.9	327.9
9	Ерөнхий боловсролын 24, 28, 34, 52, Оюуны ундраа сургуулийн гадна талбайд олон улсын стандартад нийцсэн хөл бөмбөгийн талбайн суурийн ажил /Улаанбаатар хот/	2022	2022	425.4	425.4
10	Наркологийн эмнэлгийн барилга /Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо/	2022	2024	10,573.0	2,000.0
11	Багануур үйлдвэрлэл технологийн паркийн ерөнхий цахилгаан хангамжийн 7.3 км 110 кВ-ын өндөр хүчдэлийн шугамын ажил /Улаанбаатар хот, Багануур дүүрэг/	2022	2023	2,174.1	1,174.1
12	Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай 51, 52 дугаар орон сууцны барилгыг буулган барилгажуулах төслийн гадна	2022	2022	1,044.9	1,044.9